



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 130

Улаанбаатар хот

“Арилжаа импекс” ХК-ийн  
үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 23.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-ын 3.2.4 дэх заалт, 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Арилжаа импекс” ХК-ийн оноосон нэрийг “Стандарт ноос” ХК болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Стандарт ноос” ХК /Ё.Энхтөр/-д үүрэг болгосугай.

1/ Энэхүү тогтоолын 1-д заасан оноосон нэрийн өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, энэ тухай Хороонд мэдэгдэх;

2/ Оноосон нэрийн өөрчлөлтийг ажлын хоёр хоногт багтаан хөрөнгийн биржийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд хоёроос доошгүй удаа мэдээлж, баримтыг Хороонд ирүүлэх.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000132